



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 8/43

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд 1995 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хийсэн Эрүүл мэнд, анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, 2023 онд зохион байгуулагдсан Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын 25 дугаар хуралдааны тэмдэглэл, 2021 онд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эрхүү хотын Сибирь, Алс Дорнодын тарваган тахал судлалын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, 2024 онд Монгол Улсын Эрүүл мэндийн сайд болон Оросын Холбооны Улсын Хүний эрүүл мэнд, хэрэглэгчийн эрхийг хамгаалах албатай байгуулсан хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.“Оросын Холбооны Улс, Монгол Улсын хамтын хэлэлцээрийн хүрээнд лабораторийн иж бүрэн тоноглогдсон автолаборатори”-ийг Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг боомтоос Улаанбаатарт шилжүүлэн тээвэрлэх ажлыг батлагдсан удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Захиргааны албаны Гадаад харилцаа, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн (Б.Уянга)-д үүрэг болгосугай.

2. Автолабораторийг шилжүүлэн тээвэрлэх ажлын зардал болох 1,267,520 (Нэг сая хоёр зуун жаран долоон мянга таван зуун хорин) төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

1813171159